


НХА-ын 1993 оны 282/ ур хур хууль



**БНМАУ  
УЛААНБААТАР ХОТЫН АРДЫН ХУРЛЫН  
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРГААНЫ ТОГТООЛ**

1991 оны 02 сарын 07

№ 48.

Улаанбаатар  
хот

Тохижилтын зураг төсвийн тов-  
чоо байгуулах тухай

БНМАУ-ын Сайд нарын Зөвлөлийн 1990 оны 402 дугаар тогтоолыг үндэслэн нийслэл хотын гудамж талбайн тохижилт, цэцэрлэгжүүлэлт, хот чимэглэлийн ажлыг чанартай зураг төсвөөр хангах, жижиг уран барилгын хийц хэлбэр, ур үзэмжийг сайжруулах зорилгоор Улаанбаатар хотын Ардын Хурлын гүйцэтгэх захиргаанаас ТОГТООХ нь:

1. Улаанбаатар хотын тохижилт, чимэглэлийн талаар нэгдсэн бодлого явуулах, нийтийн эзэмшлийн бүс, орон сууц, гэрийн хоороллын тохижилтын ерөнхий төлөвлөгөө, жижиг уран барилгын хэлбэрүүд, усан оргилуур, монументаль болон уран сайхны чимэглэлийн үлгэр зураг, тохижилт, цэцэрлэгжүүлэлт, гэрлэн чимэглэлийн ажлын зураг төсөв боловсруулах үүрэг бүхий хотын тохижилт чимэглэлийн зураг төсвийн товчоог 1991 оны I дүгээр улирлаас эхлэн аж ахуйн тооцооны үндсэн дээр байгуулан Улаанбаатар хотын хот тохижуулах газрын харьяанд ажиллуулсугай.

2. Зураг төсвийн товчооноос хотын тохижилтын ерөнхий төлөвлөгөө гэрэлтүүлэг чимэглэлийн үлгэр зураг, Уран барилгын жижиг оврын байгууламжийн номог катологи боловсруулахад шаардагдах хөрөнгийг гүйцэтгэлдээр нь санхүүжүүлж байхыг Хотын санхүүгийн газарт, байгууллагуудын орчны тохижилт, барилгын засварын зураг төсвийг тухайн байгууллагын зардлаар гүйцэтгэж байхыг зураг төсвийн товчоонд даалгасугай.

3. Хот тохижуулах газраас тохижилтын зураг төсвийн товчоонд захиалан хийлгэсэн нийтийн эзэмшлийн бүсийн тохижилт, гэрэлтүүлэг чимэглэлийн зураг төсвийн үнийг Хот тохижуулах арга хэмжээний зардлаас урьдчилан төлж санхүүжилт хийгдсэний

дараа хөрөнгө оруулалтаас нөхөн авч байхыг Хот тохижуулах газар /н.Отгонсүрэн/-д зөвшөөрсүгэй.

4.Зураг төсвийн товчоог хот байгуулалт, төлөвлөлттэй уялдуулан нэгдсэн удирдлагаар хангаж ажиллахыг Хотын ерөнхий архитектор /н.Мадамбаа/-д даалгасугай.



МААМБАНБААТАР ХОТЫН АРДЫН ХУРЛЫН  
БҮГДЭТГЭХ ЗАХИРГААНЫ ДАРГА..

*[Handwritten signature]*

Л. ЭНЭБИШ

ХӨБӨГ ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГА

*[Handwritten signature]*

Ч.СУМААХҮҮ